



2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Нислэгийн цаг уурын төвийн Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Шагдарсүрэнгийн Балжиннямын “Урьдчилсан мэдээлэгчдийн чадавхыг бэхжүүлэх нь 2026” сургалтад оролцох удирдамж

2026 оны 4 дүгээр сарын 12-ноос 25-ны өдрүүдэд КОЙКА олон улсын байгууллагын санхүүжилтээр Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдах “Capacity Building for Operational Weather Forecasters 2026” сэдэвт Олон улсын сургалтад Ш.Балжинням дараах удирдамжийн дагуу хамрагдана.

### **Нэг. Сургалтын зорилго**

Цаг уурын ажиглалтын мэдээ, тоон загварын прогнозын (NWP) бүтээгдэхүүн, хиймэл дагуул болон радарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх мэдлэг, ур чадварыг сайжруулах, цаг агаарын мэдээллийг олон нийт болон хэрэглэгчдэд үр дүнтэй хүргэх ойлголтыг нэмэгдүүлэхэд оршино.

Мөн хөгжиж буй орнуудад цаг уурын гамшгийн эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах мэдлэг, туршлага олж авна.

### **Хоёр: Сургалтын хөтөлбөр, агуулга:**

Сургалтын хугацаанд дараах агуулга бүхий бүлэг хичээлийг үзэж судална.

#### **Нэгдүгээр бүлэг: Цаг агаарын ажиглалт, шинжилгээ**

1. Ажиглалтын мэдээнд дүн шинжилгээ хийх;
2. Аюултай үзэгдлийн дүн шинжилгээ, урьдчилсан мэдээ;
3. Радарын бүтээгдэхүүний ойлголт;
4. Хиймэл дагуулын мэдээлэл (GK2A);

#### **Хоёрдугаар бүлэг: Цаг агаарын урьдчилсан мэдээ**

1. Урьдчилсан мэдээ боловсруулах процесс;
2. Дэвшилтэт урьдчилсан мэдээний систем;
3. Солонгосын нэгдсэн загвар (KIM) ба хэрэглээ;
4. Хиймэл оюун ухааны хэрэглээ;

#### **Гуравдугаар бүлэг: Мэдээ түгээлт ба үнэлгээ**

1. Олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх;
2. Урьдчилсан мэдээний үнэлгээ;
3. Нисэхийн цаг уурын үйлчилгээ;

**Дөрөвдүгээр бүлэг: Тайлан ба төлөвлөгөө**

1. Улсын тайлан (Country Report) боловсруулах, танилцуулах;
2. Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan) боловсруулах;
3. Төлөвлөгөөний хэлэлцүүлэг, үнэлгээ.

**Гурав: Санхүүжилт**

Нислэгийн зардал, хоол, байр болон сургалтын зардлыг БНСУ-ын KOICA байгууллагаас хариуцна.

**Дөрөв: Үр дүнг тайлагнах**

Гадаадад суралцсан тайланг ирэх сарын эхний долоо хоногт зохион байгуулагдах ус, цаг уурын салбарын Мэдээлэл солилцох цагаар дамжуулан албан хаагчдад сурсан мэдлэгээ хуваалцана.

Удирдамж боловсруулсан:

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер *Ш.Дамсанням* Ш.Балжинням

Хянасан:

Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга



Б.Болормаа

"Урьдчилан мэдээлэгчдийн чадавхыг бэхжүүлэх 2026" сэдэвт богино хугацааны  
БНСУ-д Олон улсын сургалтад хамрагдсан товч тайлан

2026.05.10

Улаанбаатар

Нислэгийн цаг уурын төвийн Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Ш.Балжинням 2026 оны 4 дүгээр сарын 12-25-ны өдрүүдэд БНСУ-д Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA) болон Солонгосын цаг уурын алба (KMA)-аас хамтран зохион байгуулсан "Урьдчилан мэдээлэгчдийн чадавхыг бэхжүүлэх 2026" (Capacity Building for Operational Weather Forecasters 2026) сэдэвт богино хугацааны олон улсын сургалтад хамрагдсан.

Энэ сургалтын зорилго нь цаг уурын ажиглалтын мэдээ, тоон загварын прогнозын (NWP) бүтээгдэхүүн, хиймэл дагуул болон радарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх мэдлэг, ур чадварыг сайжруулах, мөн цаг агаарын мэдээллийг олон нийт болон хэрэглэгчдэд үр дүнтэй хүргэх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байсан. Мөн хөгжиж буй орнуудад цаг уурын гамшгийн эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах мэдлэг, туршлага олж авах нь сургалтын нэг гол зорилго байлаа.

Уг сургалтыг KMA-ийн мэргэжилтэн, багш нар удирдан чиглүүлж, Сөүл дэх Солонгосын цаг уурын алба (KMA)-ийн танхимд явагдсан бөгөөд Камбож, Индонез, Лаос, Малайз, Монгол, Филиппин, Вьетнам зэрэг нийт 7 орны 14 суралцагч оролцсон.

Сургалт дараах сэдвүүдийн хүрээнд явагдсан. Үүнд:

➤ Нэгдүгээр бүлэг: Цаг агаарын ажиглалт ба шинжилгээ: цаг агаарын шинжилгээний ойлголт, аргачлал; аюултай цаг агаарын шинжилгээ, урьдчилсан мэдээний зөвлөмж; радарын бүтээгдэхүүний тайлбар, ашиглалт; GK2A хиймэл дагуулын бүтээгдэхүүн хэрэглээ;

➤ Хоёрдугаар бүлэг: Цаг агаарын урьдчилсан мэдээ: урьдчилсан мэдээ боловсруулах процесс, ажлын урсгал; дэвшилтэт урьдчилсан мэдээний систем; Солонгосын нэгдсэн загвар (KIM) ба хэрэглээ; хиймэл оюун ухааны цаг агаарын урьдчилсан мэдээнд хэрэглэх арга;

➤ Гуравдугаар бүлэг: Мэдээ түгээлт ба үнэлгээ: олон нийттэй харилцах, нийтийн цаг агаарын мэдээлэл түгээх; урьдчилсан мэдээний үнэлгээ, чанарын хяналт; KMA-ийн нисэхийн цаг уурын үйлчилгээ;

➤ Дөрөвдүгээр бүлэг: Улсын тайлан ба үйл ажиллагааны төлөвлөгөө: Монгол улсын цаг агаарын нөхцөл байдлын тайлан боловсруулж олон улсын мэргэжилтнүүдэд танилцуулсан; Action Plan боловсруулж, хэлэлцүүлэг хийсэн.

4 дүгээр сарын 16 болон 23-ны өдрүүдэд сургалтын үеэр оролцогчид Үндэсний цаг уурын төв, Үндэсний цаг уурын музей (Сөүл), Үндэсний цаг уурын супер компьютерийн төв (Очанг), Үндэсний хиймэл дагуулын төв (Жинчон) зэрэг байгууллагад газар дээрх үзлэг хийж, радар, хиймэл дагуул, тооцооллын дэд бүтэц болон урьдчилсан мэдээний практик үйл ажиллагаатай танилцсан.

**Дүгнэлт:** Энэхүү олон улсын сургалт нь миний хувьд олон талын ач холбогдолтой, цаг агаарын салбарын орчин үеийн дэвшилтэт технологитой танилцах үнэ цэнэтэй боломж болсон. GK2A хиймэл дагуулын бүтээгдэхүүн, радарын мэдээлэлд шинжилгээ хийх, хиймэл оюун ухааны аргуудыг цаг агаарын урьдчилсан мэдээнд хэрэглэх талаар шинэ мэдлэг олж авсан. Солонгосын нэгдсэн загвар (KIM)-ийн үйл ажиллагааны дэд бүтэцтэй танилцаж, манай байгууллагын NWP системийн хөгжилд ашиглах зарим хандлагыг тодорхойлсон. Мөн 7 орны цаг уурын мэргэжилтнүүдтэй туршлага солилцсон нь мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд чухал суурь болсон.

Тайлан бичсэн:

Нислэгийн цаг уурын төвийн

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер *Д.Сүхжин* Ш.Балжинням

국가기상슈퍼컴퓨터센터



Korea Meteorological Administration

**Capacity Building for  
Operational Weather Forecasters**

April 13~April 24, 2026

KOICA